ISO 9001:2015

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ОРХОН АЙМАГ

ISO 37001:2016

# САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ХЯНАСАН: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ............ /Б.ЗОРИГТБАЯР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

*Тэмдэг* ............

ҮНЭЛСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА ............ /Ж.БААСАНСҮРЭН /

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

2025.08.20.

ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ............ /Д.САЙЗМАА/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

*Тэмдэг*

2025.06.13

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр | Орхон аймаг

| Д/д | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм", холбогдох журам | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| *СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО-1. Дотоод аудитын бие даасан хараат бус байдлыг дээшлүүлж, төрийн байгууллагын уялдаа холбоо чадавхыг бэхжүүлнэ* | | | | | | | |
| 1.1 | **Зорилт-1 Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журмыг боловсруулан батлах, нэмэлт өөрчлөлт оруулах** | **Үйл ажиллагаа-ны зардал** | **Шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын дүрэм журамд өөрчлөлт оруулсан тоо** | **2024 онд 2 дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж баталсан.** | **2025 онд хууль, тогтоомж шинэчлэгдсэн тухай бүр хуулийн хүрээнд дүрэм, журамд өөрчлөлт, сайжруулалт хийгдэнэ.** | **Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг "Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар" болгон өөрчилсөнтэй холбоотой аймгийн Дотоод аудитын хороог 2025.04.30-ны өдөр хуралдуулж, хурлаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дүрэм, Дотоод аудит хийх журам, Санхүүгийн хяналт шалгалт хийх журам нийт 1 дүрэм, 2 журамд өөрчлөлт оруулан, хэлэлцүүлж батлуулсан.** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *-Хууль дүрэм журам өөрчлөлт орсон тухай бүр*<br>*-Нэгдсэн менежментийн тогтолцооны стандарт үйл ажиллагааны журамд нийцүүлэх* | | | | | **Зорилтын гүйцэтгэл 100%** | |
| 1.1.1 | Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журамд өөрчлөлт, шинэчлэлтийг хийх | Үйл ажиллагаа-ны зардал | Байгуул-лагад мөрдөгдөж байгаа дүрэм журамд өөрчлөлт, шинэчлэлт оруулсан тоо | 2024 онд нийт **2** дүрэм, журмыг шинэчлэн, боловсруулж баталсан. | 2025 онд хууль, тогтоомж шинэчлэгдсэн тухай бүр хуулийн хүрээнд дүрэм, журамд өөрчлөлт, сайжруулалт хийгдэнэ. | Засгийн газрын 2025.01.29-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг "Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар" болгон өөрчилсөнтэй холбоотой аймгийн Дотоод аудитын хороог 2025.04.30-ны өдөр хуралдуулж, хурлаар дараах дүрэм, журамд өөрчлөлт оруулан хэлэлцүүлж батлуулсан. Үүнд:<br>1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дүрэм<br>2. Дотоод аудит хийх журам<br>3. Санхүүгийн хяналт шалгалт хийх журам<br>Арга хэмжээний гүйцэтгэл-100% | |
| **1.2** | **Зорилт-2 Төсвийн ерөнхийлөн захирагч, дээд шатны байгууллага болон бусад байгууллагатай хамтран ажиллах**<br>*-МУЗГТ-2015 он, №483 "Дотоод аудитын дүрэм"* | **Үйл ажиллагаа-ны зардал** | **Тухай бүр** | **Хамтран ажилласан байгууллага** | **Хамтын ажиллагаа уялдаа холбоо сайжирна.** | **Сангийн яам, бусад яамд болон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Орхон аймаг дахь Төрийн аудитын газар, Орон нутгийн улсын төсөвт байгууллагуудын дээд шатны байгууллагуудтай хамтран ажиллаж, албан бичгээр тайлан, мэдээг тухай бүр хүргүүлсэн.**<br>**Зорилтын биелэлт-100%** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1 | Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тоон болон бичмэл тайлан, мэдээ, судалгаа хүргүүлэх | Үйл ажиллагаа-ны зардал | "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.9- дэх заалт дагуу жилд 2 удаа тайлан хүргүүлэх | 2024 онд 2 удаа | 2025 онд 2 удаа | Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаар **1 удаа** буюу 2024 оны жилийн эцсийн хяналт шалгалтын тоон мэдээ, бичмэл тайланг 2025.01.10-ны өдрийн 15 тоот албан бичгээр Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлж ажилласан.<br>2025 оны эхний хагас жилийн хяналт шалгалтын тоон мэдээ, бичмэл тайлан 2025.07.10-ны дотор хүргүүлж ажиллана. Тайлагнах хугацаа болоогүй.<br>Арга хэмжээний гүйцэтгэл-100% | |
| 1.2.2 | Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 тоот тушаалаар батлагдсан" Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хорооны хурлаар шийдвэрлэсэн асуудал, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр холбогдох газарт хүргүүлэх | Үйл ажиллагаа-ны зардал | Дотоод аудитын хорооны хурлын тоо | 2024 онд 2 удаа | 2025 онд 2 удаа | Аймгийн Дотоод аудитын хорооны хурлыг 2025.04.30-ны өдөр зохион байгуулсан. 2025 оны эхний хагас жилд **1 удаа** хуралдуулсан.<br>Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Дотоод аудитын хорооны дарга буюу аймгийн Засаг даргаар батлуулан, дараах 3 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэлээ. Үүнд:<br>**1.** Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг "Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар" болгон өөрчилсөнтэй холбоотой Газрын дүрэм, Дотоод аудитын журам, Санхүүгийн хяналт шалгалт хийх журамд өөрчлөлт оруулан батлуулсан.<br>**2.** Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагналаа. **(2024 оны нэгдсэн танилцуулга)**<br>3. 2025 оны Дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд 2025.03.30-ны өдрийн байдлаар Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан 9 байгууллагын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалтын дүнг танилцууллаа. **(түвшинд хамрагдсан 9 байгууллагын танилцуулга)**<br>Хорооны хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан "Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дүрэм", "Санхүүгийн хяналт шалгалт хийх журам", Дотоод аудит хийх журам"-ын төслийг гишүүдийн 100%-ийн саналаар дэмжиж Аймгийн Дотоод аудитын хорооны хурлын 01/25 дугаар тогтоолоор "Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дүрэм", "Дотоод аудит хийх журам", "Санхүүгийн хяналт шалгалт хийх журам"-ыг тус тус батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна.<br>Арга хэмжээний гүйцэтгэл-100% | |
| 1.2.3 | Байгууллагын чиг үүргийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагатай хамтран ажиллах | Үйл ажиллагаа ны зардал | Хамтран ажилласан Байгууллагын тоо | 2024 онд 5 байгууллага | 2025 онд хамтран ажилласан байгууллагын тоо | 2025 оны "Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө"-нд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, 7, 17 дугаар сургууль, 8, 23, 27, 28, Унага, Эрх бужинхан, Дэгдээхэй, Баян-Өндөр цэцэрлэгүүд, Нийцэл, Үйлсбадрах, Анхны-Од, Энхжих мандарваа, Мэндцэцэг, Мөнхийн гэгээ, Мөнхсүндрэл, Учралтбаяр зэрэг 19 байгууллагад Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх хүсэлтийг Эрүүл мэндийн яам, Боловсролын яаманд хүргүүлж ажиллалаа.<br>Жил бүр тогтмол гэрээтэй дараах байгууллагуудтай гэрээний сунгалтыг хийж ажиллалаа. Үүнд:<br>1. Хот тохижуулах газар<br>2. Стандарт хэмжил зүйн газар<br>3. Хаан банк<br>4. Орхон аймгийн шүүхийн газар<br>5. Монголын цахилгаан холбоо ХК<br>6. ЭБЦТС-ТӨХК<br>7. Эрдэнэт-Үүл ДТС ОНӨХК<br>8. Орхон аймгийн Улаан загалмайн хороо<br>9. Юнивишн ХХК<br>10. НИК ХХК<br>11. Нью компас кэй ХХК<br>12. Монголын бүтээмжийн төв | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 13. Хүнс хөдөө аж ахуйн газар<br>14. Монсерфт ХХК<br>15. Си Ти Эс ХХК<br>Мөн 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах байгууллагуудтай шинээр хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан. Үүнд:<br>1. "Үндэсний дата төв" УТҮГ<br>2. Олон улсын стандартын академи ХХК<br>3. Таван богд нура ХХК<br>4. "Түшиг ЭНЖИБИ" ХХК<br>5. "Ворлд стандарт консалтинг" ХХК<br>Арга хэмжээний гүйцэтгэл-100% | |
| **2.1** | **Зорилт-1 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын эрсдэлийг үнэлж, нэгтгэх, мэдээллийн санг баяжуулах**<br>*-Сангийн сайдын тушаал 2019 он, №268, "Улсын салбарын дотоод аудитын стандарт"*<br>*-Сангийн сайдын тушаал 2016 он, №107 "Санхүүгийн хяналт шалгалт хийх стандарт"* | **Үйл ажиллагааны зардал** | **Эрсдэлийн үнэлгээ, дотоод аудитад хамрагдсан байгууллагын тоо** | **2024 онд 60 байгууллага** | **2025 онд 60 байгууллага** | **2025 оны эхний хагас жилийн байдлаар 30 байгууллагад аймгийн Засаг даргын удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэсэн, 3 байгууллагын хяналт шалгалтын гүйцэтгэл 90%-тай үргэлжилж байна.**<br>**Нийт 27 байгууллагын эрсдэлийг "Эрсдэлийн үнэлгээний журам"-ын дагуу үнэлсэн. Үүнд:**<br>➢ **"Их" эрсдэлтэй 5 байгууллага**<br>➢ **"Дунд" эрсдэлтэй 8 байгууллага**<br>➢ **"Бага" эрсдэлтэй 14 байгууллага**<br>**Зорилтын гүйцэтгэл 90%** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Дотоод аудитад хамрагдсан байгууллагуудын эрсдэлийг үнэлж, нэгтгэн мэдээллийн санг баяжуулах | Үйл ажиллагааны зардал | Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо | 2024 онд 31 байгууллага | 2025 онд 33 байгууллага | 2025 оны эхний хагас жилийн байдлаар **21** байгууллагад **"Дотоод аудит"** гүйцэтгэж 3 байгууллагын хяналт шалгалт 90%-тай үргэлжилж байна. Дотоод аудит гүйцэтгэсэн 27 байгууллагын эрсдэлийг "Эрсдэлийн үнэлгээний журам"-ын дагуу үнэллээ.<br>Үнэлгээгээр:<br>"Их" эрсдэлтэй 4 байгууллага, "Дунд" эрсдэлтэй 4 байгууллага, "Бага" эрсдэлтэй 10 байгууллага эрсдэлтэй үнэлэгдсэн. Эрсдэлийн үнэлгээг нэгтгэн "Эрсдэлийн мэдээллийн сан"-г баяжуулсан.<br>Арга хэмжээний гүйцэтгэл-100% | |
| 2.1.2 | Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын эрсдэлийг үнэлж, нэгтгэн мэдээллийн санг баяжуулах | Үйл ажиллагааны зардал | Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо | 2024 онд 29 байгууллага | 2025 онд 27 байгууллага | 2025 оны эхний хагас жилийн байдлаар 9 байгууллагад "Санхүүгийн хяналт шалгалт" гүйцэтгэн эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан.<br>Үнэлгээгээр:<br>"Их" эрсдэлтэй 1 байгууллага, "Дунд" эрсдэлтэй 4 байгууллага, "Бага" эрсдэлтэй 4 байгууллага үнэлэгдсэн. Эрсдэлийн үнэлгээг нэгтгэн "Эрсдэлийн мэдээллийн сан"-г баяжуулсан.<br>Арга хэмжээний гүйцэтгэл-80% | |
| **2.2** | **Зорилт-2 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг эрсдэлийн үнэлгээнд суурилан төлөвлөж, стандартын дагуу үр дүнтэй, гүйцэтгэж, засаглалын** | **Үйл ажиллагааны зардал** | **Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо** | **2024 онд 60 байгууллага** | **2025 онд 60 байгууллага** | **Байгууллагын даргын 2020 оны А/17 дугаартай тушаалаар "Эрсдэлийн үнэлгээний журам"-ыг баталсан. Энэ журмаар их эрсдэлтэй байгууллагын жил тутам, дунд эрсдэлтэй байгууллагыг 1-2 жил тутамд, бага эрсдэлтэй үнэлэгдсэн байгууллагыг 2 жил тутамд 1 удаа хяналт шалгалтад хамруулахаар журамласан байдаг. Өмнөх онуудын эрсдэлийн үнэлгээнд суурилан байгууллагын 2025 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 60 байгууллагаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар 30 байгууллагын хяналт шалгалтын удирдамжийг аймгийн Засаг даргаар** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **эрсдэлийг бууруулах**<br>*-Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл*<br>*-Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 зүйл*<br>*--МУЗГТ-2015 он, №483 "Дотоод аудитын дүрэм"*<br>*-Сангийн сайдын тушаал 2019 он, №268, "Улсын салбарын дотоод аудитын стандарт"*<br>*-Сангийн сайдын тушаал 2016 он, №107 "Санхүүгийн хяналт шалгалт хийх стандарт"*<br>*-АЗДҮХ- 2024-2028 он 4.2.1.1* | | | | | **батлуулж, 27 байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан, 3 байгууллагын шалгалт 90%-тай үргэлжилж байна.**<br>**Шалгалт бүрэн дууссан 27 байгууллагыг эрсдэлийг "Эрсдэлийн менежментийн журам"-ын дагуу үнэлж "Эрсдэлийн мэдээллийн сан"-д нэгтгэн ажиллалаа.**<br>**2025 оны эхний хагас жилийн байдлаар Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2024 оны IV улирал, 2025 оны I улирлын байдлаар 2 удаагийн дотоод аудитыг гүйцэтгэн холбогдох байгууллагуудад нэгдсэн тайланг албан бичгээр хүргүүлсэн. Мөн "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан сайжруулах, арга зүйгээр хангах зорилгоор аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод хяналт, нягтлан бодогч нарт 3 удаагийн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.**<br>**Зорилтын гүйцэтгэл 100%** | |
| 2.2.1 | Улс, орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит байгууллага тусгай сан, тусгай шилжүүлэг, төсөл хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлд нийт | Үйл ажиллагаа ны зардал | Дотоод аудитад хамрагдах байгууллагы н тоо | 2024 онд 31 байгууллага | 2025 онд 29 удаагийн дотоод аудит гүйцэтгэх | 2025 оны эхний хагас жилийн байдлаар **21** байгууллагын 2024 оны төсөв санхүү, үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод аудитыг батлагдсан удирдамжийн хүрээнд 18 байгууллагын шалгалт бүрэн дуусаж, 3 байгууллагын шалгалт 90%-тай үргэлжилж байна. Үүнд:<br>**-Шалгалт бүрэн дууссан байгууллагууд:**<br>1. Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар<br>2. Хотын захирагчийн алба Болзошгүй ааварын зардал<br>3. Баян-Өндөр сумын Болзошгүй ааварын зардал<br>4. Жаргалант сумын Болзошгүй ааварын зардал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **29 удаагийн дотоод аудит гүйцэтгэх** | | | | | 5. Баян-Өндөр сумын Засаг даргын нөөц сан<br>6. Жаргалант сумын Засаг даргын нөөц сан<br>7. Эрдэнэт сан<br>8. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан<br>9. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан<br>10. Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан<br>11. Гэр бүлийн ордон Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар<br>12. Хот байгуулалт барилга захиалагчийн алба Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар<br>13. Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар<br>14. Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа<br>15. Жаргалант ус, дулаан түгээх станц ОНӨХК<br>16. Хөтөлбөр /Жаргалант сумын "Төрийн албан хаагчдыг дэмжих хөгжлийн хөтөлбөр"/<br>17. Шилэн дансны дотоод аудит 2024 оны 4-р улирал<br>18. Шилэн дансны дотоод аудит 2025 оны 1-р улирал<br><br>**-Шалгалт үргэлжилж байгаа байгууллагууд:**<br>1. Их шуутэн цогцолбор ОНӨААТҮГ<br>2. Хөрөнгө оруулалтын ажил /Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажил /Хүүхдийн паркийн тоглоом, суурилуулалт/<br>3. Аймгийн Засаг даргын нөөц сан<br><br>Дотоод аудитын тайлан, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт, албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажиллаж байна.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 2.2.2 | Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах | Үйл ажиллагаа ны зардал | Хэрэгжилтийн хувь | 2024 онд 98 хувь | 2025 онд 98 хувь, 4 удаагийн | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 84 байгууллагын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд улирал бүр буюу **4** удаагийн дотоод аудит гүйцэтгэх | | | | дотоод аудит гүйцэтгэх<br>1. **2024 оны IV улирал,**<br>2. **2025 оны I улирал**<br>3. 2025 оны II улирал<br>2025 оны III улирал | хэрэгжилтэд 2024 оны IV улирал, 2025 оны I улирлын байдлаар **2 удаагийн** дотоод аудитыг гүйцэтгэн холбогдох байгууллагуудад нэгдсэн тайланг албан бичгээр хүргүүлсэн.<br>2024 оны IV улирлын дотоод аудитын нэгдсэн дүн 99 хувьтай, 2025 оны I улирлын дотоод аудитын нэгдсэн дүн 98.5 хувьтай дүгнэгдсэн байна.<br>Дотоод аудитын дүнг танилцуулбал:<br>1. **2024 оны IV улиралд:**<br>- нэгдсэн дүн-99%<br>- хугацаандаа мэдээлсэн байдал-99.3%<br>- иж бүрэн мэдээлсэн байдал-99.6%<br><br>- 100% үнэлэгдсэн 19 байгууллага<br>- 95-99% үнэлэгдсэн 64 байгууллага<br>- 94% үнэлэгдсэн 1 байгууллага<br>2. **2025 оны I улиралд:**<br>- нэгдсэн дүн-98.5%<br>- хугацаандаа мэдээлсэн байдал-99.2%<br>- иж бүрэн мэдээлсэн байдал-99.3%<br><br>- 100% үнэлэгдсэн 56 байгууллага<br>- 95-98% үнэлэгдсэн 22 байгууллага<br>- 90-93% үнэлэгдсэн 5 байгууллага<br>- 83% үнэлэгдсэн 1 байгууллага<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 2.2.2.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан сайжруулах, арга зүйгээр хангах | Үйл ажиллагаа-ны зардал | Сургалтын тоо | 2024 онд 5 удаа | 2025 онд 5 удаа | "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан сайжруулах, арга зүйгээр хангах зорилгоор дараах сургалтыг зохион байгууллаа. **3 удаа**гийн сургалтад 73 байгууллагын 115 албан хаагч хамрагдлаа. Үүнд<br>1. Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй **8** Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн **16** дотоод хяналтын ажилтан, нягтлан бодогч нарт ажлын байранд холбогдох баримтад суурилан Засаглалын удирдлага, Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1. Төсвийн байгууллагын мэдээлэл оруулагч<br>2. Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч байгууллага<br>Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч байгууллагын мэдээлэл оруулагч, иргэн | | | | | үнэлэх, эрсдэлд суурилсан дотоод хяналтыг гүйцэтгэх мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээлэл байршуулалтыг сайжруулж, төсвийн ил тод байдлыг хангах ажиллах талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан.<br>2. 2025.05.29-ны өдөр 2024-2025 оны 1-р улирлын байдлаар улс, орон нутгийн төсвийн байгууллагуудын шинээр томилогдсон мэдээлэл оруулагч, нягтлан бодогч нарт "Шилэн дансны тухай хуулийн танилцуулга, нэмэлт өөрчлөлт, нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулалтыг сайжруулах арга зүй" сэдэвт практик сургалтад **3** байгууллагын **3** нягтлан бодогч;<br>3. 2025.05.28-ны өдөр аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллагуудын дарга, нягтлан бодогч, мэдээлэл оруулагчдад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн 2025 оны 1-р улирлын дотоод аудитын дүн **"Шилэн дансны нэгдсэн цахим систем"-д** мэдээлэл байршуулах арга зүй, илэрсэн нийтлэг зөрчил дутагдал, арга зүйн зөвлөгөөг өгч, Дотоод аудитын үр нөлөө, Засаглал, Эрсдэл, дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг үнэлэх замаар байнгын сайжруулалтыг төлөвлөх арга зүй сэдэвт цахим сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 62 байгууллагын 21 удирдах ажилтан буюу дарга, 57 нягтлан бодогчид, 18 Эрсдэл, Дотоод хяналт хариуцсан ажилтан нар тус тус хамрагдсан.<br>Мөн Оюу, 18 дугаар цэцэрлэг, Уран эгшиг, 18 дугаар сургууль, Жаргалант сумын Эрүүл мэндийн төв зэрэг 5 байгууллагын нягтлан бодогчдод ажлын байранд ганцаарчилсан зөвлөгөө өгч, 18 байгууллагын нягтлан бодогчдод утсаар мэдээлэл өгч, арга зүйгээр хангаж ажилласан байна.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.2.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын дүн, цаг үеийн мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага, цахим хуудсаар дамжуулан ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах | Үйл ажиллагаа-ны зардал | Мэдээллийн суваг буюу ТВ, байгууллагын сайтад мэдээ нийтэлсэн тоо | 2024 онд 2 удаа | 2025 онд 2 удаа | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, сурталчлах таниулах зорилгоор "Тусгал" ТВ-ээр 1 удаа мэдээний цагаар мэдээлэл, ярилцлага өгсөн, байгууллагын сайтад 3 удаагийн мэдээлэл нийт **4 удаа** мэдээ, мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан. Үүнд:<br>1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн 2024 оны Дотоод аудитын нэгдсэн дүн, холбогдох мэдээллийг "Тусгал" телевизэд 2025.04.18-ны өдөр 1 удаа ярилцлага өгч иргэд олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан.<br>2. www.sankhuu.audit.or.gov.mn газрын сайт, мэдээллийн самбарт "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын дүнг, сургалт, мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байна.<br>3. Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт *"Шилэн дансны нэгдсэн цахим хуудас-СХДАГ"*, *"Орхон Төрийн сан"* зэрэг цахим хуудсаар дамжуулан Шилэн дансны цахим системийн шинэчлэл, бүртгэл үүсгэх, мэдээлэл байршуулалттай холбоотой зөвлөгөө, мэдээллийг сар бүр хүргэж ажилласан.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 2.2.3 | Улс, орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит байгууллага тусгай сан, тусгай шилжүүлэг, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, | Үйл ажиллагаа-ны зардал | Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагын тоо | 2024 онд 29 байгууллага | 2025 онд 27 байгууллага | 2025 оны эхний хагас жилд орон нутгийн төсөвт **9** байгууллагын 2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд доорх байгууллагуудад хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>Шалгалтад:<br>**1.** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;<br>**2.** Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК<br>**3.** 7-р сургууль<br>**4.** 8-р цэцэрлэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зарцуулалт, төсвийн гүйцэтгэлд нийт **27 удаагийн санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх** | | | | | 5. 23-р цэцэрлэг<br>6. Дэгдээхэй цэцэрлэг<br>7. Баян-Өндөр цэцэрлэг<br>8. Үйлсбадрах ӨЭМТөв<br>9. Анхны-Оч ӨЭМТөв<br>Санхүүгийн хяналт шалгалтын танилцуулга, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт, ажил сайжруулах албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажилласан байна.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 2.2.4 | Удирдах дээд шатны байгууллага, бусад төрийн байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэх, холбогдох танилцуулга, тайлан, дүгнэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлэх | Үйл ажиллагаа-ны зардал | Хяналт шалгалтад хамрагдах байгууллагын тоо | 2024 онд 5 байгууллага | 2025 онд Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийгдэнэ. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Удирдах дээд шатны байгууллага, бусад төрийн байгууллага, иргэний өргөдөл гомдлын дагуу төлөвлөгөөт бус **6** удаагийн санхүүгийн хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн хүрээнд гүйцэтгэн дүгнэлт өгч ажилласан. Үүнд:<br>1. **Нийтийн номын сангийн ҮҮА-ны дарга, сан хөмрөгч Н.Отгонцэцэгийн ирүүлсэн өргөдөл, гомдол:** Аймгийн Засаг даргын 2025.01.15-ны өдрийн баталсан 05/25 дугаартай удирдамжийн хүрээнд "**Нийтийн номын сан**"-гийн төвийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>2. Аймгийн Засаг даргын 2025.02.28-ны өдрийн баталсан 13/25 дугаартай удирдамжийн хүрээнд "**Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төсөл**"-ийг хариуцах нэгжийн 2024.01 дугаар сараас-2025.02 дугаар сарын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаа, төслийн хэрэгжилт, үр дүн, Засаглалын удирдлага, Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын тогтолцоонд төлөвлөгөөт бус дотоод аудитыг гүйцэтгэлээ.<br>Шалгалтаар төслийн хэрэгжүүлэх нэгжийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг "ХАНГАЛТГҮЙ" гэж дүгнэн 7 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Аймгийн Засаг даргын 2025.05.07-ны өдрийн баталсан 28/25 дугаартай удирдамжийн хүрээнд **"Шинэ хөдөө" төслийн** 2023, 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус дотоод аудитыг гүйцэтгэсэн.<br>4. **Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025.06.03-ны өдрийн 05/2061 дугаар албан бичигт 20-р сургуулийн багш ажилчдаас тус сургуулийн захирал Д.Гантуулд холбогдох ёс зүйн зөрчил, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж буй талаар шалгаж, шийдвэрлүүлэх албан тоотыг** үндэслэн аймгийн Засаг даргын 2025.06.04-ний өдрийн баталсан 36/25 дугаартай удирдамжийн хүрээнд **"20-р сургууль"**-ийн төсөв, санхүүтэй холбоотой 8 асуудлыг тууштай хянан шалгалтыг гүйцэтгэсэн.<br>5. **Боловсролын газар, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ** зэрэг 2 байгууллагын 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд хяналт шалгалтын хийж байна. Шалгалт 90%-тай үргэлжилж байна.<br>Төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүү хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг холбогдох газруудад албан бичгээр, хариуцсан байгууллагын удирдлага, нягтлан бодогч, холбогдох ажилчдад танилцуулж, зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэх талаар үүрэг болгон ажилласан.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 2.2.5 | Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тоон тайлан нэгтгэх | Үйл ажиллагаа-ны зардал | Жилд 4 удаа | 2024 онд тоон тайлангийн нэгтгэл 4 удаа | 2025 онд тоон тайлангийн нэгтгэлийг 4 удаа нэгтгэн мэдээлэх | 2025 оны I, II улиралд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын тоон мэдээг **2 удаа** нэгтгэн дүгнэсэн.<br>2025 оны эхний хагас жилийн нэгтгэсэн тоон тайлангаар төлөвлөгөөт 27 байгууллага, төлөвлөгөөт бус 4 байгууллага нийт 31 байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэн 156 зөрчил илрүүлж, 10,597.70 мянган төгрөгийн 10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлбөрийн акт, 159,412.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 7 албан шаардлага, ажил сайжруулах 7,339,663.90 мянган төгрөгийн өртөг бүхий 130 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:<br>➢ **Төлөвлөгөөт:** дотоод аудит-18, санхүүгийн хяналт шалгалт-9 нийт 27 байгууллага<br>➢ **Төлөвлөгөөт бус:** дотоод аудит-2, санхүүгийн хяналт шалгалт-2 нийт 4 байгууллагад хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1 | **Зорилт-1 Хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах**<br>*-Шилэн дансны тухай хууль*<br>*-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль*<br>*-Авлигын эсрэг хууль*<br>*-Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль*<br>*Төрийн албаны тухай хууль*<br>*-НМИТБТХ 8.4.3, 8.4.6, 8.4.7, 8.4.8, 8.4.9.*<br>*-АХ-2050 Зорилго-2, Зорилт-2.2,* | **Үйл ажиллагаа -ны зардал** | **Хэрэгжилт-ийн хувь** | **2024 онд 98 хувь** | **2025 онд 98 хувь** | **2025 оны эхний хагас жилд байгууллагын хяналтад байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, дүрэм, журам, хөтөлбөрийн биелэлтийг 100% хангаж ажиллалаа. Үүнд:**<br>➢ **"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.4.3, 8.4.6, 8.4.7, 8.4.8, 8.4.9 дэх нийт 5 заалтын хэрэгжилт**<br>➢ **Байгууллагын "Мэдээллийн сан"-д бүртгэлтэй, хяналтад авсан 11 тогтоол, шийдвэрийн хэрэгжилт**<br>➢ **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хуралдааны 1 тэмдэглэлийн хэрэгжилт**<br>➢ **Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох "Хүний эрхэд суурилсан засаглал" бүлгийн Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдлын 4.2.1.1, Цахим засаглал, төрийн үйлчилгээний 4.3.1.5, 4.3.1.6 дахь нийт 3 зорилтын хэрэгжилт**<br>➢ **Аймгийн Засаг даргын баталсан 7 захирамжийн хэрэгжилт** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *-Ерөнхийлөгчийн зарлиг 2013.06.10, №88 -УИХБХТоатоол 1.3, -УИХ-ын тогтоол 2014.05.01, №15, 2024.04.18 №24, ЗГ-ын тогтоол 2020 он, №206, ЗГ-ын тогтоол 2011 он, №311, ЗГ-ын 2023 он, №301, АЗДҮАХ-2024-2028 он, 4.2.1.1, 4.3.1.5, 4.3.1.6* | | | | | ➢ **Аймгийн Засаг даргын "Шуурхай зөвлөгөөн"-өөс өгөгдсөн 8 үүрэг даалгаврын биелэлт болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажилласан.**<br><br>**Зорилтын гүйцэтгэл 100%** | |
| 3.1.1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Үйл ажиллагаа-ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | Байгууллагын хяналтад байгаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 заалт (8.4.3, 8.4.6-8.4.9)-ын хүрээнд аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдалд Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулах хуулийн хугацаа, мэдээлбэл зохих талбаруудад 2024 оны IV улирал, 2025 оны I улирлын байдлаар 2 удаа дотоод аудитыг гүйцэтгэн ил тод байдалд дүгнэлт өгч, нэгдсэн тайланг дээд шатны байгууллагуудад улирал бүр хүргүүлсэн.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар хуулийн хэрэгжилтийг 100% хангаж ажилласан.<br>Биелэлтийг тогтоосон хугацаанд буюу 2025.06.20-ны өдрийн дотор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т и-оффис системээр хүргүүлж ажиллана.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |

<table>
<tr>
<td>3.1.2</td>
<td>Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах</td>
<td>Үйл ажиллагаа-ны зардал</td>
<td>Хэрэгжилт-ийн хувь</td>
<td>2024 онд 98 хувь</td>
<td>2025 онд 98 хувь</td>
<td>Байгууллагын мэдээллийн санд бүртгэлтэй, хяналтад авсан 11 тогтоол, шийдвэр байна. Үүнд:<br>
<table>
<tr><th>№</th><th>Тогтоол, шийдвэр</th><th>Тоо</th><th>Хяналтад авсан заалтын тоо</th></tr>
<tr><td>1</td><td>Ерөнхийлөгчийн зарлиг</td><td>1</td><td>2</td></tr>
<tr><td>2</td><td>Улсын Их Хурлын тогтоол</td><td>2</td><td>3</td></tr>
<tr><td>3</td><td>Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол</td><td>1</td><td>2</td></tr>
<tr><td>4</td><td>Монгол улсын Засгийн газрын тогоол</td><td>3</td><td>3</td></tr>
<tr><td>5</td><td>Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</td><td>3</td><td>4</td></tr>
<tr><td>6</td><td>Засгийн газрын албан даалгавар</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td colspan="2">Нийт дүн</td><td>11</td><td>15</td></tr>
</table>
Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хяналтад байгаа тогтоол, шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой арга хэмжээг төлөвлөн батлуулж, эхний хагас жилийн байдлаар тогтоол, шийдвэрийн биелэлтийг 100% хангаж ажилласан. Хэрэгжээгүй болон биелэлт тасарсан, удааширсан тогтоол шийдвэр байхгүй.<br>
2025 оны эхний хагас жилийн тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тогтоосон хугацаанд буюу 2025.06.20-ны өдөр хүргүүлнэ.<br>
Арга хэмжээний гүйцэтгэл 100%</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>3.1.3</td>
<td>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон Хурлын зөвлөлийн</td>
<td>Үйл ажиллагаа-ны зардал</td>
<td>Хэрэгжилт-ийн хувь</td>
<td>2024 онд 100 хувь</td>
<td>2024 онд 100 хувь</td>
<td>2025 онд хяналтад байгаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хуралдааны 1 тэмдэглэлийн хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Үүнд:</td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажиллах | | | | | 1. **Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл** /2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн/<br>2. **Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол** /Журам батлах тухай 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 159 дугаар тогтоол/<br>3. **Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол** /Журам батлах тухай 2017 оны 04 дүгээр сарын 28–ны өдрийн 49 дугаар тогтоол/<br>2025 оны эхний хагас жилийн биелэлтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тогтоосон хугацаанд буюу 2025.07.01-ний өдөр хүргүүлнэ.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.4 | "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан холбогдох заалтыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа-ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох "Хүний эрхэд суурилсан засаглал" бүлгийн Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдлын 4.2.1.1, Цахим засаглал, төрийн үйлчилгээний 4.3.1.5, 4.3.1.6 дахь нийт 3 зорилтын хэрэгжилтийг 100% хангаж ажилласан.<br>2025 оны эхний хагас жилийн хөтөлбөрийн биелэлтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тогтоосон хугацаанд буюу 2025.06.20-ны өдөр хүргүүлнэ.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.5 | Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Үйл ажиллагаа-ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | 2025 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагад хамаарах аймгийн Засаг даргын баталсан **7** захирамжийн биелэлтийг 100% хангаж ажилласан. Үүнд:<br>1. **2025.01.02-ны өдрийн А/01 дугаартай** "Шуурхай зөвлөгөөний дэг батлах тухай" **захирамж**<br>2. **2025.01.10-ны өдрийн А/17 дугаартай** "Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц, орон тоог батлах тухай" **захирамж**<br>3. **2025.02.11-ний өдрийн А/126 дугаартай** "Цалин хөлсний хэмжээ шинэчлэн батлах тухай" **захирамж** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. **2025.03.18-ны өдрийн А/208 дугаартай** "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах тухай" **захирамж**<br>5. **2025.03.28-ны өдрийн А/257 дугаартай** "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай" **захирамж**<br>6. **2025.04.05-ны өдрийн А/270 дугаартай** "Шуурхай зөвлөгөөний дэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" **захирамж**<br>7. **2025.04.30-ний өдрийн А/361 дугаартай** "Бүх нийтээр мод тарих хаврын ажил зохион байгуулах тухай" **захирамж**<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.6 | Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах | Үйл ажиллагаа-ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | 2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын "Шуурхай зөвлөгөөн"-өөс 8 үүрэг даалгавар өгөгдөж, үүрэг даалгаврын биелэлтийг 100% хангаж ажилласан.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.7 | Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа-ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Аймгийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн байгууллагын "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 7 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн байгууллагын даргаар батлуулан, хэрэгжилтийг 100% хангаж ажиллаж байна.<br>Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн биелэлтийг тайлагнан 2025.06.02-ны өдөр, "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г биелэлтийг тайлагнан 2025.06.10-ны өдөр тус тус аймгийн ЗДТГ-ын ХЗЗХ-т цахимаар болон цаасаар хүргүүлж ажилласан.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.8 | Албан хаагчдын мэдэгдэл тайлбар, ХАСУМ болон ХАСХОМ хуулийн хугацаанд гаргаж мэдүүлэх | Үйл ажиллагаа-ны зардал | ХАСУМ болон ХАСХОМ, мэдэгдэл тайлбар мэдүүлэгч албан хаагчийн тоо | 2024 онд ХАСУМ мэдүүлэгч-2, ХАСХОМ мэдүүлэгч-7. | 2025 онд ХАСХОМ мэдүүлэгч-7 албан хаагчийг хуулийн хугацаанд мэдүүлэх | 2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын 2025 оны А/10 дугаартай батлагдсан бүтэц орон тооны хүрээнд төрийн захиргааны 9 албан хаагчаас ХАСХОМ-ийг мэдүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны 7 албан хаагчийн мэдүүлгийн хуулийн хугацаанд мэдүүлсэн.<br>Байгууллагын дарга Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст харьяалагдаж, ТЗ-9 ангилалд ажилладаг Хяналт-шалгалтгэ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн ХАСХОМ мэдүүлэх бүртгэлд хамаардалгүй болно.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.9 | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа-ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх 8 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар 100% хангаж ажилласан. Үүнд:<br>➢ 2025 онд Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцэн нярвын үүрэгт ажлаас чөлөөлөгдөж Дотоод аудиторын албан тушаалд томилогдож ажиллаж буй Мөнхдалгэр овогтой Алтанзулаас Засгийн газрын 2017 оны 246 тогтоолоор батлагдсан Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан Маягт №2-оор "Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа" гаргуулан авч, "Төрийн болон албаны нууц"-ын тухай хуулиар мэдлэг өгч, нууцын баталгааг хувийн хэрэгт хавсаргав.<br>➢ Албан хаагчдын ээлжийн амралт эхэлж байгаатай холбогдуулан нарлатай үед ашиглах зорилгоор албан хаагчдыг ээлжийн амралт болон эзгүй үед компьютер, И-Оффис системд нэвтрэх нэр, нууц үгийг бүртгэх бүртгэлийн хуудсаар авлаа.<br>➢ Орхон аймаг дахь Тагнуулын газраас аймгийн хэмжээнд төрийн байгууллагын нууц хариуцсан албан хаагчдад зохион байгуулсан 2 удаагийн сургалтад байгууллагын нууц хариуцсан албан хаагч хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ 2024.05.21-ний өдөр Хүний эрхийн комиссын Орхон аймаг дахь референт Ц.Батзаяа "Хүний хувийн мэдээлэл хамгаалах асуудал" сэдвээр Байгууллагын албан хаагчдад ажлын байранд дотоод сургалтыг зохион байгууллаа.<br>Тагнуулын ерөнхий газрын Орхон аймаг дахь газраас 2024.05.22-ны өдрийн 39/139 тоот албан бичгийн хүрээнд холбогдох маягтын дагуу албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх бүртгэл, тайлан мэдээг бэлтгэн 2025.06.09-ний өдөр албан бичгээр хүргүүлсэн.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.10 | Байгууллагын төсөв санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд НББОУС мөрдөж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардал | Тайлагнах тоо | 2024 онд хуулийн хугацаанд 2 удаа тайлагнасан | 2025 онд Санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр 2 удаа, төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа тогтоосон хугацаанд тайлагнах | Байгууллагын төсөв санхүү, Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд НББОУС мөрдөн, дараах тайлан мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан. Үүнд<br>1. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гарган цахимаар илгээж, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн, хянуулж, хуулийн хугацаанд баталгаажуулж ажилласан.<br>2. 2025 оны эхний хагас жилийн байдлаар **5 удаагийн буюу 1-5 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 5 удаагийн** Нийгмийн даатгалын тайлан, **1 удаа**гийн Татварын тайланг бэлтгэн аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Татварын газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.<br>Мөн Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 оны төсөв, санхүүгийн тайлан, санхүүгийн баримтад аудит хийж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган биелэлтийн тайланг хүргүүлж ажилласан.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.11 | Байгууллагын төсвийн хөрөнгийн төлөвлөлт, | Үйл ажиллагааны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах "Шилэн дансны тухай хууль"-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг мэдээллийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зарцуулалтын ил тод байдлыг мэдээлж, "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | | | | | самбарт болон Шилэн дансны цахим системд тухай бүр байршуулан ажиллаж байна.<br>Дотоод аудитаар 128 талбар бүхий мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн мэдээлж 2024 оны IV улиралд 100%, 2025 оны I улиралд 100%-тай дүгнэгдсэн байна.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.11.1 | Байгууллагын өмч, эд хөрөнгийн бүртгэл тооллого хийх, орон нутгийн өмчийн газартай тооцоо нийлэх | Үйл ажиллагаа ны зардал | Тооллогын тоо | 2024 онд 2 удаа | 2025 онд хагас жил, бүтэн жилээр 2 удаа гүйцэтгэх ОНӨГ-тай 2024 оны үндсэн хөрөнгийн тооцоо нийлэх | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд байгууллагын даргын 2025.05.22-ны өдрийн А/26, дугаартай тушаалаар байгууллагын өмний хагас жилийн "Эд, хөрөнгийн тооллогын комисс"-ыг томилсон.<br>Тооллогоор машин тоног төхөөрөмж дансны үлдэгдэл 41,086.0 мянган төгрөг, тавилга эд хогшил дансны үлдэгдэл 26,308.2 мянган төгрөг, бараа материалын тайлангаарх үлдэгдэл 3,479.5 мянган төгрөг байна.<br>Байгууллагын эд хөрөнгийг албан хаагчдын хөрөнгийн карттай тулгах нэмэлт, өөрчлөлтийг хийлээ. Тооллогын тайлан, үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулж ажилласан.<br>2024 оны хөрөнгийн бүртгэлийг Улсын болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын www.umch.gov.mn/financialReport/financialStatusReport системд мэдээлж, 2025.04.14-ний өдөр "Орон нутгийн өмчийн газар"-тай тооцоо нийлж, "Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар"-т илгээж баталгаажуулан ажилласан.<br>2025.05.16-ны өдрийн 94 дугаартай албан бичгээр "Орон нутгийн өмчийн газар"-т 4 ширхэг 3,064.6 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг актлах саналыг хүргүүлсэн.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.11.2 | Төрийн албаны тухай хуулийн хүрээнд | Үйл ажиллагаа ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 95 хувь | 2025 онд 95 хувь | Төрийн албаны тухай хуулийн хүрээнд "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах | | | | | ажлыг 2025 онд 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар 100% хангаж ажиллалаа. Үүнд: Онцлох ажлаас дурдвал:<br>➢ Орхон аймгийн Улаан загалмайн хорооны "Ивээн тэтгэгч" гишүүнээр хамтран ажилладаг. 2025 оны хамтын ажиллагааны хүрээнд 1 албан хаагчийн гэр бүлийн 1 хүнийг "Нүдний болор солиулах" хагалгаа, эмчилгээнд хамруулсан. Хагалгаа, эмчилгээний зардлыг Улаан загалмайн нийгэмлэгээс бүрэн шийдвэрлэсэн.<br>➢ 2025 оны 3-р сард Улаанбаатар хотын "Таван богд Нура" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрт илрүүлэг 11 албан хаагч 10,780.0 мянган төгрөгөөр хамруулсан.<br>➢ Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу Монголын уламжлалт "Цагаан сарын баяр"-ыг тохиолдуулан 4 ахмад настанд нийт 400.0 мянган төгрөгийн тэтгэмж олголоо.<br>➢ Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр нийт 8,461.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч албан хаагчдын өрөө тасалгааны тохижилт хийсэн.<br>➢ Албан хаагчдыг мэргэжүүлэх, ажлын байран дээр хөгжил чиглэлээр тогтмол ажлын байранд болон дээд шатны байгууллага, мэргэжлийн холбоод, сургагч багш нартай хамтран төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулж ажиллаж байна.<br>2025 оны эхний хагас жилийн хөтөлбөрийн биелэлтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т 2025.05.27-ны өдөр цахимаар болон цаасаар хүргүүлсэн.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.12 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн | Үйл ажиллагааны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | Байгууллагын даргын 2024 оны А/30 дугаартай тушаалаар "Ёс зүйн дэд хороо"-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангах | | | | | 2025 оны ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган боловсруулж, байгууллагын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 100% хангаж ажилласан. Үүнд:<br>➢ Шинээр томилогдсон 1 албан хаагчид "Төрийн албаны ёс зүйн тухай хууль", Ёс зүйн дүрэм, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.<br>➢ 2025 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гомдол ирээгүй болно.<br>➢ Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад хамрагдсан. Үүнд:<br>- "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт сургалтад байгууллагын "Ёс зүйн дэд хороо"-ны гишүүд хамрагдсан.<br>- 2025.02.20-ны өдөр "Төрийн албаны зөвлөл" Орхон аймагт ажиллах үеэр зохион байгуулсан сургалтад Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн танхимаар, бусад албан хаагчид цахимаар сургалтад хамрагдлаа.<br>- "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хөйд бүсийн зөвлөгөөнд Ёс дэд хорооны 1 гишүүн оролцлоо.<br>➢ Ёс зүйн дэд хорооноос нийт албан хаагчдад 2 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>- "Хамт олны стресс менежмент"<br>- "Байгууллага дахь зөрчлийн сэтгэл зүй"<br>➢ Сар бүр албан хаагчдыг идэвхжүүлэх арга хэмжээг "Удирдамж"-аар баталгаажуулан хэрэгжүүлэлтийг хангаж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг "Төрийн албаны Орхон аймаг дахь салбар зөвлөл"-д хүргүүлж ажилллаа.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.13 | Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа ны зардал | Хадгаламж-ийн нэгжийн тоо | 2024 онд 80 хадгаламж-ийн нэгж үүсгэн архив-ласан. | 2025 онд үүсэх хадгаламж-ийн нэгжийг архивлах | Байгууллагын 2025 оны архивын хадгаламжийн нэгжийг цахимд шилжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн байгууллагын даргаар хянуулан батлуулж, хэрэгжилтийг 100% хангаж ажилласан.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын архивд байнга хадгалах хадгаламжийн нэгжид **40** нэгжийн баримт материал, далан жил хадгалах **6** нэгжийн баримт, түр хадгалах **31** нэгжийн баримт, **нийт 77** нэгжийн баримтыг цахим болон цаасаар архивлаж, бүртгэсэн.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.14 | Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах /Эцэг эхийн зөвлөл/ | Үйл ажиллагаа ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 100 хувь | 2025 онд 100 хувь | Эцэг эхийн зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөг 1 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг 100% хангаж ажилллаа. Үүнд /онцлох ажлаас дурдвал/<br>➢ Байгууллагын 11 албан хаагчдын 3-28 насны 23 хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг 8 асуулгын хүрээнд шинэчлэн гаргалаа.<br>➢ 11 албан хаагчийн хүүхдүүдийн дугуйлан, секц, хөгжлийн хөтөлбөрт хамрагддаг судалгааг гаргаж, 1 албан хаагчийн 1 хүүхэд буюу нийт 11 хүүхэдэд тус бүр 100.0 мянган төгрөгийн секц, дугуйлангийн төлбөрийг шийдвэрлэлээ.<br>➢ "Биеийн тамир спортын газар"-тай 2025.03.01-2025.06.01-ний хугацаанд 3 сарын гэрээ байгуулан албан хаагчид болон тэдний хүүхдүүд 7 хоногт 1 удаагийн оролтоор 2 цагийн гар бөмбөгийн секцэд хамрагдлаа.<br>➢ 1 албан хаагчийн 1 хүүхэдэд "Таеквандогийн Олон улсын тэмцээн"-д оролцоход 300.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан Орхон аймгийн Гэр бүл, хүүхэд зохион байгуулсан **"Бүх хайраа гэр бүлдээ"** өдөрлөгт албан хаагчид хүүхдүүдийн хамт үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.<br>➢ 11 албан хаагчийн 7-18 насны 10 хүүхэдэд "Түшиг ЭнЖиБи" ХХК-тай гэрээ байгуулан ***"Генетик тест"***-ийн оношилгоонд **хамруулж**, сэтгэл зүйч П.Нямжаргал багш ганцаарчилсан болон эцэг эхтэй хамтарсан ярилцлагыг хийж, хүүхэд, эцэг эхчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.<br>➢ "Улаан загалмайн хороо"-ны ивээн тэтгэгч болж, гишүүнчлэлийн хүрээнд ***"Өрхийн эрсдэлийн үнэлгээ"***-г хийж, "**Өрхийн бэлэн байдлыг төлөвлөгөө**"-г гаргасан.<br>Эцэг эхийн зөвлөлийн 2025 оны эхний хагас жилийн тайлан "Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар"-т и-оффис системээр болон цаасаар 2025.06.02-ны өдөр хүргүүлж ажилласан.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.15 | Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаандаа хэвшүүлэх | Үйл ажиллагаа ны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 95 хувь | 2025 онд 100 хувь | Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2025 оны ажлын төлөвлөгөөг 1 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг 100% хангаж ажиллалаа. Үүнд:<br>➢ Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS 6395:2022 стандартын шаардлагын хангасан байгууллагын 13 албан бланк хэрэглэж байна.<br>➢ 2025 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын 41 тушаалыг кирил, үндэсний бичгээр хослуулан гаргасан.<br>➢ Байгууллагын мэдээллийн самбарууд дахь байгууллагын хаягийг кирилл болон монгол бичгээр хөрвүүлэн хэвлэлийн газраар бэлтгүүлэн байршуулсан.<br>➢ MNS7004:2023 стандартын хүрээнд албан хаагчдыг компьютерт монгол бичгээр бичих, шивэх Mongolian Bait бичих заавар хөтөч линкийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суулгаж өгсөн. Албан хаагч бүр бичих дадлагыг чөлөөт цагаараа хийж, ур чадвараа сайжруулан ажиллаж байна.<br>➢ Үндэсний бичиг үсгийн баяр-2025"-т монгол бичгийн "Алтан жонх" тэмцээнд 3 албан хаагчийг оролцууллаа.<br>➢ 2025 оны байгууллагын "Сургалтын төлөвлөгөө"-д тусгасны дагуу "Насан туршийн суралцахуй төв"-тэй хамтран "Үндэсний бичгийн зөв бичгийн дүрэм"-ийн сургалтад албан хаагчид хамрагдсан.<br>➢ Цахим хуудсанд бие даан суралцах боломжтой цахим талбаруудыг байршуулан хамт олноороо суралцаж байна.<br>➢ Албан хаагчдаас "Монгол бичгийн сорил" авахад байгууллагын албан хаагчдын унших чадвар бүгд сайжирсан, кириллээс монгол бичигт хөрвүүлэх буюу галиглах чадвар дунд, компьютер дээр болон гараар бичих чадвар дунд түвшинд үнэлэгдсэн. Өмнөх онтой харьцуулахад ахисан үзүүлэлттэй гарсан.<br>Аймгийн Засаг даргын 2024.05.24-ний өдрийн 02/1664 дугаартай албан бичгээр Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг энэ оны эхний хагас жилийн байдлаар аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст 2 удаа И-оффис системээр хүргүүлж ажилласан.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.16 | Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үйл ажиллагааны зардал | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо | 2024 онд 2 удаа | 2025 онд 2 удаа | Монгол Улсын Засгийн газрын 2020.12.09-ний өдрийн 206 дугаар тогтоол, Орхон аймгийн Засаг даргын 2022.11.03-ны өдрийн А/715 тоот захирамжаар батлагдсан "Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаар **1 удаа** байгууллагын 2024 оны жилийн эцсийн тогтоол шийдвэр, хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтэд батлагдсан төлөвлөгөөний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу 2025.01.02-ны өдрөөс 2025.01.10-ны өдрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн.<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үндсэн 3 хэсгийг үнэлсэн.<br>➢ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт<br>➢ Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт /дотоод аудит, санхүү хяналт шалгалтын төлөвлөгөөний гүйцэтгэл, хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт зэрэг багтсан/<br>➢ Байгууллагын ил тод байдал /шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, web, facebook хуудсанд ил тод мэдээлэл байршуулалт/<br>Төлөвлөгөөний дагуу 14 үзүүлэлтээр хяналт-шинжилгээ үнэлгээ гүйцэтгэхэд ерөнхий үнэлгээгээр **98,5%** хувьтай үнэлэгдсэн.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.17 | Монгол улсын Засгийн газрын 311 дугээр тогтоолын хэрэгжилтийг хангах байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах | Үйл ажиллагаа-ны зардал | Дотоод хяналт хийсэн тоо | 2024 онд 2 удаа | 2025 онд 2 удаа | Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай нийтлэг журмын хэрэгжилтийг хангах зорилгоор газрын дотоод хяналт шалгалтын нэгжийг 2 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2025 онд байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт гүйцэтгэх нэгжийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.<br>Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөнд тусгасны дагуу 2025.06.02-оос 2025.06.04-ны өдрүүдэд байгууллагын 2025 оны эхний 5 сарын байдлаарх санхүүгийн баримт материалд тулгуурлан үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар нийт 2 зөрчилд ажил сайжруулах чиглэлээр 5 зөвлөмжийг өгсөн. 2025 оны 5 сарын байдлаарх санхүү, аж ахуйн үйл ажиллагааг "**ХАНГАЛТТАЙ**" гэж дүгнэлээ. Дүгнэлт, зөвлөмжийг газрын дарга, нягтлан бодогч, нярав танилцуулан мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан. | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>Арга хэмжээний гүйцэтгэл 100%</td><td></td></tr>
<tr><td>3.1.18</td><td>"Тэрбум мод хөдөлгөөн", "Ногоон-Эрдэнэт хөтөлбөр"-ийн хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх</td><td>Үйл ажиллагаа-ны зардал</td><td>Тарьсан модны тоо</td><td>2024 онд 50 ширхэг мод</td><td>2025 онд 50 ширхэг мод</td><td>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2025.04.30-ний өдрийн А/361 дугаартай захирамжаар "Бүх нийтийн мод тарих" ажилд 2025.05.09-ний өдөр байгууллагын бүх албан хаагчид 60 ширхэг шар хайсыг хуваарьт талбайд тарьсан. Мөн 2025.06.06-ны өдөр Захиргааны III байрны гадна талбайн явган замын хэсэгт 80 ширхэг шар хуйс мод тарилаа.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100%</td><td></td></tr>
<tr><td>3.1.19</td><td>Хуваарьт талбайн 50м2 газрын цас мөс, хог хаягдлыг цэвэрлэх, ахуйн болон цаасан хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр албан хаагчдад сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах</td><td>Үйл ажиллагаа-ны зардал</td><td>Хог, цас мөс цэвэрлэсэн тоо,</td><td>2024 онд 12 удаа</td><td>2025 онд 12 удаа</td><td>2025 оны эхний хагас жилийн байдлаар Захиргааны III байрны гадна хуваарьт 50м2 талбайн цасыг 3 удаа цэвэрлэж иргэдийн зорчих хэсгийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Мөн хаврын улиралд хуваарьт талбай хог, шарилжийг түүх, их цэвэрлэгээнд 3 удаа нийт 6 удаагийн бүх нийтийн ажилд оролцож, холбогдох тайланг тухай бүр 7 хоногийн мэдээгээр аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100%</td><td></td></tr>
<tr><td>3.1.20</td><td>Байгууллага, иргэд, албан хаагчдаас ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх</td><td>Үйл ажиллагаа-ны зардал</td><td>Өргөдлийн тоо</td><td>2024 онд 46 өргөдөл</td><td>2025 онд байгууллага, иргэд, албан хаагчдаас ирсэн өргөдлийн тоо</td><td>2025 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагад 16 өргөдөл ирсэн байна. Үүнд:<br>
<table>
<tr><th rowspan="2">Хэнээс</th><th colspan="4">Өргөдлийн төрөл</th><th rowspan="2">Нийт</th></tr>
<tr><th>Мэдэгдэл</th><th>Гомдол</th><th>Санал</th><th>Хүсэлт</th></tr>
<tr><td>Албан хаагчдаас ирсэн</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>15</td><td>15</td></tr>
<tr><td>Иргэнээс ирсэн</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td>Нийт</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>16</td><td>16</td></tr>
</table></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өргөдөл, гомдлыг И-оффис системээр бүртгэн, хяналтад авч, холбогдох албан хаагч өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, цахим системд хааж ажилладаг. Байгууллагад ирсэн 18 өргөдлийг 100% шийдвэрлэсэн.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлангаар дундаж хоног 4 хоногийн хугацаанд бүрэн шийдвэрлэж ажилласан байна.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 3.1.21 | Төрийн жинхэнэ албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, бусад албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан батлах, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр авч, дүгнэж үнэлэх | Үйл ажиллагаа-ны зардал | Албан хаагчийн тоо | 2024 онд 9 албан хаагч | 2025 онд 11 албан хаагч | 2025 оны 1 дүгээр сард төрийн захиргааны 8 албан хаагч Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний 3 албан хаагчийн ажлын төлөвлөгөөг боловсруулан байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг байгуулагдан 2025.06.12-ны өдөр 11 албан хаагчийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэлээ.<br>Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн дундаж хувь 92% байна.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 4.1 | **Зорилт-1 Нэгдсэн менежментийн тогтолцоог төлөвшүүлж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалтыг хийх**<br>*-Авлигын эсрэг хууль* | **Үйл ажиллагаа-ны зардал** | **Хэрэгжилт-ийн хувь** | **2024 онд 95 хувь** | **2025 онд 95 хувь** | **"Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд байнгын сайжруулалт хийх ажлын төлөвлөгөө"-д тусгагдсан Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандарт, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын хэрэгжилтийг тус тус 100% хангаж ажиллаж байна.**<br>**"Ворлд стандарт консалтинг" ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 2025.05.12-13-ны** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *-АХ-2050 Зорилт 1.3* | | | | | **өдрүүдэд байгууллагын Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001:2015 (Чанарын менежментийн тогтолцоо), ISO 37001:2016 (Авлигын эсрэг менежментийн тогтолцоо) стандартуудын хэрэгжилтэд зөрүүний шинжилгээ /GAP/ хийлгэлээ. Зөрүүгийн шинжилгээ хийх аудитын багийн ахлагчаар ISO 9001:2015, ISO 37001:2016 Олон улсын стандартуудын Тэргүүлэх аудитор Д.Цэрэнжав, багийн гишүүн ISO 9001:2015, ISO 37001:2016 Олон улсын стандартуудын Тэргүүлэх аудитор Э.Халиун нар ажилллаа.**<br><br>**Зорилтын гүйцэтгэл 100%** | |
| 4.1.1 | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлан аудитад хамрагдах | Үйл ажиллагаа ны зардал | Аудитад хамрагдах тоо | 2024 онд баталгаажуу -лах аудитад 1 удаа хамрагдсан | 2025 онд баталгаажуу-лах аудитад 1 удаа хамрагдана. | "Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд байнгын сайжруулалт хийх ажлын төлөвлөгөө"-д тусгагдсан Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын хэрэгжилтийг хангахад дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>➢ Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, зөвлөмж өгч ажилласан.<br>➢ Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор байгууллагын нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан стандарт үйл ажиллагааны журам, чанарын гарын авлагад холбогдох өөрчлөлтийг хийж, удирдлагад танилцуулж ажилласан.<br>➢ Сэтгэл ханамжийн судалгааны асуулгын 2 удаа шинэчлэн боловсруулж байгууллагын цахим сайтад байршуулсан.<br>➢ Сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны I, II улирлын байдлаар нэгтгэж ахлах мэргэжилтэн, удирдлагад танилцуулж ажилласан.<br>➢ 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотод Олон улсын стандартын академийн сургалтад албан хаагчдын хамт бүгд Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015, Авлигын эсрэг менежментийн тогтолцоо ISO | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 37001-2016, Эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO 31000-2018 Олон улсын стандартуудын сургалтад хамрагдсан.<br>➢ "Насан туршийн суралцахуйн төв"-тэй хамтран 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 31 албан хаагч хамрагдлаа.<br>2025 оны давтан аудитад 2025 оны 10-11 сард хамрагдана. */Хугацаа болоогүй./*<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 4.1.2 | Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 олон улсын стандартын магадлан аудитад хамрагдах | Үйл ажиллагаа ны зардал | Аудитад хамрагдах тоо | 2024 онд баталгаажуу-лах аудитад 1 удаа хамрагдсан | 2025 онд баталгаажуу-лах аудитад 1 удаа хамрагдана. | Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд байнгын сайжруулалт хийх 2025 оны ажлын төлөвлөгөө"-д тусгагдсан Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын хэрэгжилтийг хангахад дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>➢ Авлигын эсрэг менежментийн тогтолцооны 37001:2016 олон улсын стандартын 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, зөвлөмж өгч ажилласан.<br>➢ Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор байгууллагын нэрсийн өөрчлөгдсөнтэй холбогдуулан стандарт үйл ажиллагааны журам, чанарын гарын авлагад холбогдох өөрчлөлтийг хийж, удирдлагад танилцуулж ажилласан.<br>➢ Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан хаагчдаас "Авлигын эсрэг тандалтын судалгаа"-г боловсруулан 2025 оны эхний хагас жилийн байдлаар дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан 33 байгууллагаас цахимаар авч ажиллалаа.<br>➢ Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, соён гэгээрүүлэх, өөрийн байгууллагын үйл ажиллагаанд Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001-2016 Олон улсын стандартыг нэвтрүүлсэн сайн туршлагаа хуваалцан 180 орчим төрийн албан хаагчдыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулсан 5 удаагийн үйл ажиллагаанд иттэл танилцуулж ажилласан байна<br>➢ Байгууллагын http://sankhuu.orkhon.gov.mn/ цахим хуудсанд 10 удаа, "Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба" фэйсбүүк пэйж хуудсанд 15 удаа, Ил тод байдлын самбарт 4 удаа авлигын эсрэг зурагт үзүүлэн, стандарттай холбогдох мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулан ажилласан.<br>2025 оны даатан аудитад 2025 оны 10-11 сард хамрагдана. /Хугацаа болоогүй./<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 4.1.3 | Байгууллагын үйл ажиллагаанд чанарын дотоод аудит гүйцэтгэх | Үйл ажиллагааны зардал | Чанарын дотоод аудитын гүйцэтгэх тоо | 2024 онд 2 удаа | 2025 онд 2 удаа | Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 37001:2016 Олон улсын стандартуудын нийцэлд "Ворлд стандарт консалтинг" ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд зөвлөгөө/зөрүүгийн шинжилгээ буюу чанарын дотоод аудитыг гүйцэтгүүлсэн.<br>Аудитыг 123 шалгуур үзүүлэлтээр үнэлж, 4 зөвлөмж өгч, үл тохиролгүй дүгнэгдсэн.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 4.1.4 | Байгууллагад хэрэгжүүлж буй "Соёлын хөтөлбөр"-ийн төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардал | Хэрэгжилт-ийн хувь | 2024 онд 95 хувь | 2025 онд 100 хувь | "Соёлын хөтөлбөр"-ийг байгууллагадаа 2 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд Соёлын хөтөлбөрийн хүрээнд 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилд хэрэгжих төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна. Үүнд:<br>➢ Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан "Байгууллагын стандарт"-ыг бүх албан хаагчдад хэвшүүлэх зорилгоор баримтлах зарчим, тавигдах шаардлага тус бүрийг дотоод группээр 10 удаа мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан.<br>➢ Байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 12 сар тус бүрд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэр өгч, сар бүр нэршилтэй холбоотой арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.<br>➢ Соёлын хөтөлбөрийн хүрээнд "Бусдын эрх ашгийг хүндэтгэн хамтран ажиллах", "Бусдыг мэдэрч ойлгох" сэдвэт 2 удаагийн сургалтыг Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулсан.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 4.2 | **Зорилт-2<br>Өсөн дэвжих эрмэлзэлтэй, чадахуйн зарчимд суурилсан, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх**<br>*-Төрийн албаны тухай хууль 55 дугаар зүйл 55.3,<br>-Сангийн сайд болон Орхон аймгийн Засаг даргын 2025 онд хамтран ажиллах гэрээний 3.41,<br>-Төрийн албаны зөвлөлийн зөвлөмж 2020.11.05* | **Үйл ажиллагааны зардал** | **Сургалын тоо, албан хаагчийн тоо** | **2024 онд 41 удаагийн сургалтад давхардсан тоогоор 350 албан хаагч** | **2025 онд 41 удаагийн сургалтад хамрагдах** | **Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган, байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах сургалтыг зохион байгуулж, мөн дээд газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна. Үүнд:<br>1. Гадагш чиглэсэн 7 удаагийн сургалтаар 270 төрийн байгууллагын албан хаагч, аж ахуй нэгжийн төлөөлөл оролцсон.<br>➢ Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангуулах 3 удаагийн сургалтаар 112 байгууллагын удирдах ажилтан, нягтлан бодогч, дотоод хяналт ажилтан, мэдээлэл оруулагч нар<br>➢ Сайн туршлага хуваалцсан /манлайлал/ 4 удаагийн сургалтаар 270 төрийн албан хаагч<br>2. Албан хаагчдыг мэргэшүүлэх 44 удаагийн сургалтад давхардсан тоогоор 316 албан хаагч хамрагдсан.<br>➢ Дээд газраас зохион байгуулсан 17 удаагийн сургалтад давхардсан тоогоор 47 албан хаагч<br>➢ Дотооддоо буюу ажлын байранд зохион байгуулсан 23 удаагийн сургалтад давхардсан тоогоор 229 албан хаагч<br>➢ 4 удаагийн Зөвлөгөөн, форумд давхардсан тоогоор 40 албан хаагч** | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Зорилтын гүйцэтгэл 100%** | |
| 4.2.1 | Санхүүгийн хяналт шалгалтын стандарт болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын чиглэлээр Дотоод аудиторуудыг сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулах | Үйл ажиллагааны зардал | Сургалтын тоо, албан хаагчийн тоо | 2024 онд 3 удаагийн сургалтад 10 албан хаагч | 2025 онд 3 удаагийн сургалтад хамрагдах | Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт шалгалтын стандарт болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын чиглэлээр Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, Дотоод аудиторуудыг сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулах 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 14 албан хаагчдыг хамруулж ажиллалаа. Үүнд:<br>➢ 2025.03.21-ний өдөр Улаанбаатар хотод "Дотоод аудиторуудын институт"-тэй гэрээ байгуулж, багш Ж.Жаргалсүрэнгээс Засаглах удирдлага, гүйцэтгэх удирдлага, хараат бус дотоод аудитын талаар дэлгэрэнгүй ойлголт авч, "Жаргалант ус, дулаан түгээх станц" ОНӨХК-нд хийсэн дотоод аудитын тайланд үндэслэн дадлага ажил хийж, бодит кейс дээр ажиллан харилцан мэдээлэл солилцож, зөвлөгөө зөвлөмж авсан. Сургалтад байгууллагын бүх албан хаагч<br>➢ Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын газраас санаачлан Монгол улсын Сангийн яамтай хамтран 2025.05.30-ны өдөр зохион байгуулсан Дотоод аудитор, СХШУБ (СХШУАБ) нарыг чадавхжуулах, мэдлэг мэдээлэл солилцох "Үзүүлэх сургалт"-д байгууллагын 4 албан хаагч<br>➢ Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ хамтран 2025.05.29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан "Хамтын хөгжил-Сайн туршлага" сэдэвт зөвлөгөөнд 2 албан хаагч<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 4.2.2 | Албан хаагчдыг мэргэшүүлэх болон бусад сургалтад хамруулж, мэдлэг чадвар | Үйл ажиллагааны зардал | Сургалтын тоо, албан хаагчийн тоо | 2024 онд 38 удаагийн сургалтад 340 албан хаагч | 2025 онд 38 удаагийн сургалтад хамрагдах | Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаар **40** удаагийн сургалтад давхардсан тоогоор **276** албан хаагчийг хамруулж, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, сургалт мэдээллээр хангаж ажиллалаа. Үүнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чадамжийг дээшлүүлэх | | | | | ➢ Дээд газраас зохион байгуулсан **17** удаагийн сургалтад давхардсан тоогоор **47** албан хаагч<br>➢ Дотооддоо буюу ажлын байранд зохион байгуулсан **23** удаагийн сургалтад давхардсан тоогоор **229** албан хаагч /Дотоод сургалтын Эрүүл мэндийн газар, Насан туршийн суралцахуйн төв, Орхон аймгийн Улаан загалмайн хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын Орхон аймаг дахь референт Ц.Батзаяатай мөн бусад мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран зохион байгуулсан/<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 5.1 | **Зорилт-1 Байгууллагын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах**<br>*-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль*<br>*-ЗГ-ын 2024.09.04-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэл*<br>*-АЗДҮАХ-2024-2028 он, 4.2.1.1* | **Үйл ажиллагааны зардал** | **Хэрэгжилт-ийн хувь** | **2024 онд 90 хувь** | **2025 онд 95 хувь хүргэх** | **Байгууллагын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараах ажлыг зохион байгуулж ажилллаа. Үүнд:**<br>➢ **Байгууллагын http://sankhuu.orkhon.gov.mn/ цахим хуудсанд 67 удаа, "Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба" фэйсбүүк пэйж хуудсанд 89 удаа, Ил тод байдлын самбарт 12 удаа байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулан ажилласан.**<br>➢ **Албан хаагчид өдөр тутмын ажлын төлөвлөгөө, бичиг төлөвлөлт, тайлан мэдээгээ И-оффис системд бүртгэн, илгээж хэвшсэн.**<br>➢ **Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn сайтад 2025 оны I, II улирал тус бүр 5 бүлгийн 87 талбарт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан.**<br>➢ **Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn/mn сайтад байгууллагын нээлттэй мэдээллийг байршуулсан.**<br>**Зорилтын гүйцэтгэл 100%** | |
| 5.1.1 | Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, зохион | Үйл ажиллагааны зардал | Цахим сайт болон телевизийн | 2024 онд http://sankhuu.orkhon.gov | 2025 онд байгууллагын http://sankhuu.o | 2025 оны эхний хагас жилд байгууллагын http://sankhuu.orkhon.gov.mn/ цахим хуудсанд 67 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллага, хүний нөөц төсөв, санхүү ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах | | мэдээлэлт-ийн тоо | .mn сайтад 79 удаа, Тусгал телевизэд-4 удаа мэдээ мэдээлэл бэлтгэн нийтлүүлсэн | rkhon.gov.mn сайтад 85 удаа, ил тод байдлын мэдээллийн самбарт 12 удаа, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад 4 удаа мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлнэ | удаагийн мэдээ, мэдээллийг байршуулж ажилласан байна. Үүнд:<br>- Гадаад болон дотоод сургалттай холбоотой мэдээлэл<br>- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны тайлан, мэдээг танилцуулсан мэдээлэл<br>- Нэгдсэн менежментийн тогтолцооны хүрээнд хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл<br>- Байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой мэдээлэл<br>Байгууллагын "Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба" фэйсбүүк пэйж хуудсанд **89 удаа** байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагч, иргэдэд хэрэгтэй мэдээ, мэдээллийг байршуулан ажилласан.<br>Ил тод байдлын самбарт байгууллагын 2025 оны батлагдсан төсөв, бүтэц, орон тоо, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сар бүрийн үйл ажиллагааны тайлан зэрэг мэдээллүүдийг сар бүр буюу **12 удаа** самбар байршуулж ажилласан.<br>Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хийсэн 2024 оны IV, 2025 оны I улирлын дотоод аудитын дүн, холбогдох мэдээллийг "Тусгал" телевизийн "Мэдээллийн хөтөлбөр"-т **1** удаа өгч иргэд, олон нийтийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 5.1.2 | И-оффис системийн ашиглалтыг сайжруулах | Үйл ажиллагаа-ны зардал | Системд бүртгэгдсэн баримт бичгийн тоо | 2024 онд ирсэн бичиг-243, явсан бичиг-249, албан хаагчдын ажлын төлөвлөгөө-458, өргөдөл гомдол-48, | 2025 онд онд ирсэн бичиг, явсан бичиг, албан хаагчдын ажлын төлөвлөгөө, өргөдөл, гомдол, үүрэг даалгаврын тоо, | Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн И-Оффис системийн ашиглалт, бүртгэлийн тоо **670** байна. Үүнд:<br>- Явсан бичиг- 124<br>- Ирсэн бичиг-117<br>- Өргөдөл гомдол-16<br>- Төлөвлөсөн бичиг-165<br>- Хурлын болон албаны даргаас өгсөн үүрэг даалгавар-18<br>- Албан хаагчдын ажлын төлөвлөгөө-224 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үүрэг даалгавар-70. | | - Дотоод зар, мэдээ, мэдээлэл байршуулсан тоо -6<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 5.1.3 | Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn цахим системийн ашиглалтыг сайжруулах | Үйл ажиллагаа-ны зардал | Цахим системд байршуул-сан тоо | 2024 онд 1 удаа | 2025 онд 4 удаа | Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журам" мөн 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын дагуу Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn сайтад 2025 оны I, II улиралд тус бүр 5 бүлгийн 87 талбарт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй мэдээллийг хуулийн хугацаанд эхний хагас жилийн байдлаар **2 удаа** байршуулсан.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны www.shilen.gov.mn сайтад нийтлэгддэг "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ"-ээр 2025 оны I улиралд 98%-ийн биелэлттэй үнэлэгдсэн. 2025 оны II улирлын нээлттэй байдлын үнэлгээ хийгдээгүй байна.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 5.1.4 | Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст байгууллагын мэдээлэл байршуулах | Үйл ажиллагаа-ны зардал | Цахим хуудаст байршуул-сан мэдээллийн тоо | - | 2025 онд байгууллагын үйл ажиллагааны баримт материалуудыг цахим хуудаст байршуулсан байна. | Байгууллагын болон админ хэрэглэгчийн www.gov.mn хаягийг нээлгэх хүсэлтийг "Үндэсний дата төв"-д албан бичгээр хүргүүлж, 2025.01.08-ны өдрийн ЦДШХ/25-09 дугаартай Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах цахим шуудан домайн нэр олгох үйлчилгээний гэрээ байгуулж байгууллагын админ эрх буюу цахим хуудсанд мэдээлэл байршуулах веб сайтын мэйл www.admin@sankhuu.orkhon.gov.mn, хэрэглэгчийн эрх буюу байгууллагын цахим шуудангийн мэйл www.info@sankhuu.orkhon.gov.mn хаягуудыг тус тус нээлгэсэн.<br>Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mnmn сайтад -Нутгийн захиргааны байгууллагууд -Орхон аймаг--Орхон аймгийн Засаг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даргын Тамгын газрын -Харьяа байгууллагууд-Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нэрээр байгууллагын нэлттэй 4 мэдээллийг байршуулсан. Үүнд:<br>➢ Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоо<br>➢ Албан хаагчдын нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар<br>➢ Байгууллагын чиг үүрэг, бидний тухай мэдээлэл<br>➢ 2025 онд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудын батлагдсан жагсаалт<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |
| 5.1.5 | Санхүүгийн хяналт шалгалтын стандарт болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөж дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг стандартын дагуу гүйцэтгэх, www.audit.mof.gov.mn дотоод аудитын мэдээллийн системд иж бүрэн байршуулах | Үйл ажиллагааны зардал | Дотоод аудит, хяналт шалгалтын тоо | 60 | 2025 онд дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын хяналт шалгалтын мэдээллийг www.audit.mof.gov.mn системд иж бүрэн байршуулах. | Дотоод аудитын удирдлагын мэдээллийн систем болох www.audit.mof.gov.mn -д 2025 оны эхний хагас жилийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан төлөвлөгөөт 27, төлөвлөгөөт бус 4 **нийт 31** байгууллагын ажлын баримт холбогдох хязгаарлагдаагүй мэдээллийг Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, дотоод аудиторууд өөрсдийн тусгай эрхээр нэвтрэн байршуулан ажилласан.<br>Арга хэмжээний гүйцэтгэл 100% | |

ОРХОН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

2025-06-20 Орхон аймаг

| д/д | Зорилт / Үнэлгээ | | Бүгд | Гүйцэтгэлийн зорилт 1 | Гүйцэтгэлийн зорилт 2 | Гүйцэтгэлийн зорилт 3 | Гүйцэтгэлийн зорилт 4 | Гүйцэтгэлийн зорилт 5 | Гүйцэтгэлийн зорилт 6 | Гүйцэтгэлийн зорилт 7 | Гүйцэтгэлийн зорилт 8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээний тоо | | 54 | 2 | 4 | 3 | 7 | 24 | 5 | 3 | 6 |
| 2 | 6.2.1 буюу 100% ба түүнээс дээш | | 27 | 2 | 1 | | 2 | 14 | 5 | 1 | 2 |
| | | 95.0% | 1 | | | | | | | 1 | |
| | | 94.0% | 1 | | | | | | | | 1 |
| | | 93.3% | 1 | | 1 | | | | | | |
| | | 91.7% | 1 | | | | | 1 | | | |
| | | 90.0% | 15 | | 2 | 1 | 4 | 4 | | 1 | 3 |
| | | 80.0% | 1 | | | 1 | | | | | |
| | | 70.0% | 7 | | | 1 | 1 | 5 | | | |
| Ерөнхий үнэлгээ, хувь | | | **Бүрэн хангалттай** 92.4% буюу 4.62 оноо | 100% буюу 5.0 оноо | 93.3% буюу 4.66 оноо | 80.0% буюу 4.0 оноо | 90.0% буюу 4.5 оноо | 91.7% буюу 4.58 оноо | 100% буюу 5.0 оноо | 95.0% буюу 4.75 оноо | 94.0% буюу 4.7 оноо |

ХЯНАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ЗОРИГТБААР

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БААСАНСҮРЭН